Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# ДАШИНЧИЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025.12.16

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт ” үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 1.1. | “Залуусын хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | ОНТ | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Төлөвлөгөөг 90-с дээш хувиар хэрэгжүүлнэ. | "Залуусын хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Залуучуудын дунд 5 удаагийн сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 268 залуучууд хамруулсан байна. 7 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, давхардсан тоогоор 824 иргэнийг хамруулан 4,994,500 төгрөгийг зарцуулсан. Олон улс болон аймгийн чанартай 2 удаагийн тэмцээн уралдаанд оролцсон 7 залууст 630,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. 12 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулж, сумын нийт залуучуудын 63 хувийг хамруулсан байна. Булган аймгийн урд бүсийн залуучуудын аварга шалгаруулах спортын 3-н төрөлт тэмцээн амжилттай оролцсон. Тус тэмцээний эрэгтэй волейболын төрөлд 1-р байр, Эмэгтэй волейболын төрөлд 2-р байр, Ширээний теннис эрэгтэй төрөлд Б.Дашдаваа 3-р байр, Дартсны эмэгтэй төрөлд Болормаа 1-р байр, Шилдэг довтлогчоор А.Батмэнд, Шилдэг холбогчоор Г.Солонго нар тус тус шалгарч, багийн дүнгээр 2 дугаар байр эзлэсэн байна. Баг тамирчдын тэмцээний шатахууны зардалд 250,000 төгрөгийг олгосон. Төлөвлөгөөний хэрэгжилт 70,8 хувь байна. | 85 |
| 1.2. | Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх | ОНТ | Хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагаа тогтмолжсон. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-с дээш хувиар биелүүлнэ. | Хамтарсан багийн гишүүдийг аймгийн ГХГБХХГ, МИГ даатгалтай хамтран зохион байгуулсан хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 4 удаагийн сургалт, ажлын байранд нь чадавхжуулах 1 өдрийн сургалтад тус тус хамруулсан. ХГБНАжилтныг Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан 5 хоногийн чадавхжуулах, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэшүүлэх сургалт, "Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүчирхийллийн хохирогч хүүхдэд өгөх анхан шатны зөвлөгөө мэдээлэл" сэдэвт 1 өдрийн сургалтад тус тус хамруулсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар байдлаар хүүхдийн тусламжийн 108 утсанд үл хайхрах, гэр бүлийн хүчирхийллийн шинж чанартай 5 дуудлага ирсэн. Дуудлагын дагуу Хамтарсан баг нөхцөл байлын үнэлгээ хийж, шийдвэрлэн ажилласан байна. | |
| 1.3. | Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | ОНТ | Сургалт, нөлөөллийн ажлын тоо, хамрагдсан иргэдийн тоо | Нийт иргэдийн 5 хувьд хүрсэн. | 12 удаагийн арга хэмжээнд, нийт иргэдийн 20-с доошгүй хувийг хамруулна. | 2025 оны жилийн эцсийн байдлаар гэр бүлийн боловсрол олгох сургалтыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 130 иргэнийг хамруулсан. ХГБХХГ-аас бэлтгэсэн "Гэр бүлийн боловсрол олгох" 8 модуль цуврал сургалтыг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн давхардсан тоогоор 928 иргэнд хүргэсэн. Гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн танилцуулгыг 4 багийн 124 иргэнд хүргэсэн. ЕБС-ийн дотуур байрны сурагчдад "Гэр бүлийн хүчирхийл, хүчирхийлэл түүний төрлүүд" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 75 сурагч хамрагдсан. | 100 |
| 1.4. | "Ургаа мэдвэл-Улсаа мэднэ" аяныг хэрэгжүүлэх | ОНТ | Хамрагдсан өрхийн тоо | Тодорхой ажил хийгдээгүй. | 100-с доошгүй өрхийг угийн бичиг хөтөлсөн байна. | Төрийн албан хаагчдаас түвшин тогтоох шалгалтыг авсан. Монгол бичгийн сургалтыг 4 удаа хийж, давхардсан тоогоор 65 албан хаагч хамрагдсан. | 80 |
| 1.5. | Гэр бүлийн, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах | ОНТ | Гэр бүлийн хүчирхийллийг бууруулсан хувь, Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулсан тоо | Сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. | Өмнөх оноос буурсан байна. | ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд "Гэр бүлийн хүчирхийлэл", "Утаат болон электрон тамхины хор хөнөөл, үр дагавар", "Үе тэнгийн дээрэлхэлт" сэдвийн хүрээнд Дэвжээ тэмцээнийг зохион байгуулж, 30 сурагч хамрагдсан. Гэр бүлийн хүчирхийлэл, хорт зуршил, дэлгэцийн донтолтын талаар нөлөөлийн ажлыг 3 удаа зохион байгуулж, 225 сурагч хамрагдсан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй иргэний судалгааг гаргаж, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг зурагт самбарыг сумын төвийн 4 цэгт байршуулсан. ХГБХХГазрын сэтгэлзүйчтэй хамтран эрсдэлт нөхцөл дэх айлуудад "Гэр бүлийн боловсрол" сургалтыг явуулын үйлчилгээгээр хүргэж, сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө мэдээллийг 4 өрхийн 6 иргэнд хүргэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.6. | Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн хариу үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | ОНТ | Хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, насанд хүрэгчдийн хувь | Бүртгэгдсэн кейсийн 75 хувьд хүрч ажилласан. | Бүртгэгдсэн кейсийн 95 хувьд хүрч ажиллана. | ЕБС-ийн сурагчдын дотуур байранд Хамтарсан багийн гишүүн Б.Дашдаваа, хэсгийн төлөөлөгч Б.Нямдорж, Сургуулийн нийгмийн ажилтан нартай хамтран сургалт нөлөөллийн ажлыг 5 удаа хийж, хамрагдвал зохих хүүхдийг 100 хувь хамруулсан. Мөн “Охидын эрүүл ахуй” сэдэвт сургалтыг зохион байгуулж, охидын нандин хайрцгийг байршуулж, хэрхэн хэрэглэх зөвлөгөө, зааврыг хүргэж ажилласан. | 100 |
| 1.7. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх | ОНТ | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 3 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг явуулсан. | Төлөвлөгөөг 90-с дээш хувиар хэрэгжүүлнэ. | Жендэрийн дэд салбар хороог 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулсан. Хорооны гишүүдээс "Ажлын байрны жендэрийн мэдрэмжийг үнэлэх" асуулгыг шалгуур үзүүлэлтийн дагуу авсан. Мөн “Харилцан хүндэтгэе” сарын аяны хүрээнд 7-9 дугаар ангийн сурагчдын дунд “Дэвжээ” тэмцээнийг Жендэр, сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Тус тэмцээнд 5 багийн 30 сурагч хамрагдсан. Тэмцээний шагналын зардалд ОНХС-аас 240,000 төгрөг зарцуулсан байна. Мөн аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан "Жендэр" сэдэвт цахим сургалтад сум, сургуулийн нийгмийн ажилтан, НБМ хамрагдсан. ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад Жендерийн талаарх сургалт нөлөөллийн ажлыг 3 удаа зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 235 сурагч хамрагдсан байна. | 85 |
| 1.8. | "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийг хэрэгжүүлэх | ОНТ | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Төлөвлөгөөг 90-с дээш хувиар хэрэгжүүлнэ. | “Чадварлаг мэргэжилтэн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан, ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. | 50 |
| 1.9. | Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх | ОНТ | Бэлтгэсэн ажилтаны тоо | Тодорхой ажил хийгдээгүй. | 10 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг ЕБС-н 12 дугаар ангийн 27 сурагчдад, 8-11 дүгээр ангийн 44 сурагчдад зохион байгуулсан. Ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг 35 иргэнд өгсөн. | 85 |
| 1.10. | Зорилтот бүлгийн өрхийн мэргэжилгүй, ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны иргэдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг ахиулах сургалтад хамруулах | ОНТ | Сургалтад хамруулсан иргэдийн тоо | Тодорхой ажил хийгдээгүй. | 10 | Халамжаас-Хөдөлмөрт шилжих 20 өрхийн 5 иргэнийг төсөл бичих сургалтад, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад 12 иргэн, бусад сургалтад 15 иргэнийг хамруулсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.11. | Малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх | УТ, ТХ | Хамрагдсан өрхийн тоо | 24 өрх хамрагдсан | 10-аас доошгүй өрхийг малжуулна. | ХЭДС-аас зарлагдсан малжуулах төсөл хөтөлбөрт 4 өрх хамрагдаж 32 сая төгрөгийн зээлийг авсан. | 100 |
| 1.12. | Шинээр бий болсон ажлын байрыг бүртгэн мэдээлэх | УТ | Шинээр бий болсон ажлын байр | Нийт 20 ажлын байр | Нийт 30 ажлын байр | 2025 онд шинээр 66 ажлын байр бүртгэхээс байнгын ажлын байранд 50, түр ажлын байранд 1, улирлын ажлын байранд 10, нийт 61 ажлын байр шинээр бүртгэсэн байна. Ажилд зуучлах үйлчилгээнд 108 иргэн бүртгэхээс 57 иргэнийг бүртгэсэн. | 100 |
| 1.13. | Бага, дунд орлоготой иргэдийг аж ахуй эрхлэлтийг дэмжих жижиг зээлд хамруулах | ТХ | Зээлд хамрагдсан иргэдийн тоо | 2 өрхийг | 2 өрхийг | ХЭДС-с ахмадын ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 4 ахмад хамрагдаж, 32 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төсөл хөтөлбөрт 2 иргэн хамрагдаж, 18 сая төгрөг, иргэдийн ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 1 иргэн хамрагдаж, 10 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан. | 100 |
| 1.14. | Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт хэлэлцээрийг хэрэгжүүлэх | ОНТ | Хэлэлцээрийн хэрэгжилтийн хувь | 80 хувь | 90-с дээш хувиар хэрэгжүүлнэ. | Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2025-2026 оны хэлэлцээрийг 2025 оны 05 дугаар сард шинэчлэн байгуулсан. | 90 |
| 1.15. | Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэнийг ажлын байраар хангах | ТХ, ОНТ | Ажлын байраар хангасан иргэдийн тоо | 5 иргэнийг ажлын байраар хангах | 5-8 иргэнийг | Халамжаас-Хөдөлмөрт хөтөлбөрийн хүрээнд "Зөв 20" өрхийн 5 гишүүнийг байнгын ажлын байранд зуучилсан. | 90 |
| 1.16. | "Зөв өрх-20" өрхөд чиглэсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | ОНТ, ТХ | Өрхийн хөгжлийг дэмжих төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 20 өрхийг хамруулна | 90-с дээш хувиар хэрэгжүүлнэ. | Зөв 20 өрхийг шинэчлэн дэлгэрэнгүй судалгааг гаргасан. Зөв 20 өрхийн 4 иргэнийг ажлын байранд зуучилсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн малжуулах төсөл хөтөлбөрт 2 иргэн хамрагдсан. | 85 |
| 1.17. | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж санхүүгийн дэмжлэг олгох | ТХ | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн тоо | 1-2 ахмадад үйлчилгээ үзүүлсэн байна. | 1-2 ахмадад үйлчилгээ үзүүлсэн байна | ХЭДС-с ахмадын ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 4 ахмад хамрагдаж, 32 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төсөл хөтөлбөрт 2 иргэн хамрагдаж, 18 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан. | 100 |
| 1.18. | Ахмад настан, ХБИ-ийн дунд урлаг, спортын наадам, соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг | ОНТ | Зохион байгуулсан сургалт, нөлөөлийн ажлын тоо | ХБИ-н дунд 1, Ахмад настнуудын дунд 1 удаа тэмцээнийг | Тус бүр 2 удаагийн нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 200-с | Булган аймгийн Дашинчилэн, Баяннуур, Булган сумын ахмадуудын дунд "ДУРСАМЖ УУЛЗАЛТ 2025" нөхөрсөг спортын тэмцээн болон Дуун цэнгүүнийг зохион байгуулж, нийт 77 ахмад хамрагдсан байна. Тэмцээний шагналын зардалд 650,000 төгрөг зарцуулсан байна. | 85 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж, хөгжлийг дэмжих | | | зохион байгуулсан. | доошгүй иргэдийг хамруулна. | Мөн Рашаант суманд зохион байгуулагдсан Дашинчилэн, Рашаант сумын ахмадуудын дунд "Бид үе тэнгийнхэн" спортын нөхөрсөг уулзалт тэмцээн зохион байгуулагдаж, сумаас 14 ахмадууд оролцсон. Тэмцээний бооцооны мөнгө болон шатахууны зардалд 375,000 төгрөг зарцуулсан. Сар бүрийн 10-ны өдөр ахмадын дуун цэнгүүн, улирал бүр Софт волейболын тэмцээн зохион байгуулагдаж хэвшсэн. Ахмадын баярын арга хэмжээг зохион байгуулж, ахмадын дунд АХА, Софт волейбол, хамтлаг бүжиг, шатар, ширээний теннисний тэмцээнүүдийг зохион байгуулж, 180 ахмад хамрагдсан. Бууз 1*10 аяныг зохион байгуулж, 1735 буузыг хөгжлийн бэрхшээлтэй зорилтот бүлгийн 6 өрхөд өгсөн. Хөгжлийн бэрхшээлтэй, бусдын асаргаанд байдаг 5 хүүхэд, 5 хүнд хэвтрийн өвчтөн, 44 байнгын асаргаатай иргэнийг ЭМТ-тэй хамтран гэрийн эргэлт хийж, үзлэг, шинжилгээнд хамруулан, дархлаажуулах эм бэлдмэлийг олгосон. Мөн ахмадын баяраар байнгын асаргаатай 14 ахмадад хүнс, цагаан идээний дэмжлэг үзүүлсэн. | |
| 1.19. | Иргэдийн спорт наадам зохион байгуулах /олон төрөлт/ | ОНТ | Зохион байгуулсан тэмцээн, Хамрагдсан иргэдийн тоо | 5,0 | 10, 2000 | Урд бүсийн иргэдийн спортын наадмын 1 дүгээр үе шат Дашинчилэн суманд зохион байгуулагдсан. Тус тэмцээнд Булган аймгийн урд бүсийн Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант сумын нийт 290 гаруй тамирчид оролцож, Волейбол, Ширээний теннис, Шатар, Шагайн харваа, Үндэсний сур харваа гэсэн төрлүүдээр өрсөлдсөн. Спортын наадмын шагналын зардалд ОНХС-аас 905,500 төгрөг зарцуулсан байна. Бүсчилсэн хөгжлийн "Иргэдийн спортын их наадам" 2025 оны 04 дүгээр сарын 18-20 өдрүүдэд Булган аймагт үндэсний спортын 3 төрөл, спортын 4 төрлөөр явагдсан. Тэмцээнд 4 бүсийн иргэд оролцож Дашинчилэн бүсд тэргүүлсэн баг тамирчид амжилттай оролцж, багийн нийлбэр дүнгээр Дашинчилэн бүс 2-р байранд орсон. Тэмцээний шатахууны зардалд ОНХС-аас 150,000 төгрөг зарцуулсан байна. Бүсчилсэн хөгжил "Иргэдийн спортын их наадам" 2025 оны 05 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд Булган аймагт үндэсний бөх, үндэсний сурын харваа, шагайн харваа, волейбол, сагсан бөмбөг, шатар, ширээний теннис | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэсэн 7-н төрөлд 3 насны ангилалд 400 гаруй тамирчид оролцон амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд Булган аймгаа төлөөлөн Дашинчилэн бүсээс ахмадын волейболын баг тамирчид амжилтай оролцлоо. Тэмцээнд оролцсон тамирчдын шатахууны зардалд 75,000 төгрөг зарцуулсан байна. | |
| 1.20. | Төрийн болон ТББ, ААН-үүдэд спорт хамтлагийг байгуулж, ажилтан, албан хаагчдыг ажлын байрны дасгал хөдөлгөөн хийлгэж хэвшүүлэх | ОНТ | Ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн байгууллагын тоо | 3 байгууллага дасгал хийж хэвшсэн. | 6 | Монгол улсын ерөнхийлөгчийн санаачлагаар өрнөж буй Эрүүл Монгол хүн хөдөлгөөний хүрээнд “Идэвхтэй алхалтад-Цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээг 2025.05.15-2025.06.20-ны хооронд зохион байгуулж, аяны хүрээнд байгууллага бүр спорт хамтлагтай болох ажил хийгдэж, одоогоор ЗДТГ, ЭМТ, ЕБС спорт хамтлаг байгуулаад байна. Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг албан байгууллага бүр тогтмол хийж хэвшсэн. | 85 |
| 1.21. | Спортын холбоодтой хамтарч ажиллах, бодлогоор дэмжих | ОНТ | Хамтарч ажилласан холбоодын тоо | 1 холбоотой хамтран ажилласан | 3 холбоотой хамтарч ажилласан байна. | Сумын хэмжээнд МСУХ, Хар бух шагайн холбоодын үйл ажиллагаа тогтмолжсон байна. Хар бух шагайн холбоог хичээллэх байраар хангасан. Мөн 2025 онд шагайн харвааны 3 удаагийн тэмцээнийг зохион байгуулж, 1 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн байна. Хар бух шагайн холбооноос үйл ажиллагаагаа иргэд, хүүхэд багачуудад сурталчлах зорилгоор нээлттэй өдөрлөгийг 1 удаа зохион байгуулсан. | 90 |
| 1.22. | Улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудлах цэг байгуулах газрын асуудлыг шийдвэрлэх | УТ | Гэрчилгээжүүлсэн байдал. | - | Газрын асуудлыг шийдвэрлэсэн байна. | Засгийн газрын 2024 оны 189 дүгээр тогтоолын дагуу мянганы зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах газрыг 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган, дуудлага худалдаагаар эзэмшүүлсэн. | 100 |
| 1.23. | “Нэг өрх-Жуулчин гэр” төсөлд малчдыг хамруулах | ТХ | Хамрагдсан өрхийн тоо | - | 5-с доошгүй өрхийг хамруулна | Ажил хийгдээгүй. | 0 |
| 1.24. | ААН-үүдийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар сургалт зохион байгуулах | ОНТ | Хамрагдсан аж ахуй нэгжийн тоо | - | ААН-үүдийн 90-с дээш хувийг хамруулна. | Булган аймагт орон нутгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, зочид буудал, жуулчны бааз, зоогийн газрын удирдлага, ажилчдын мэргэшлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг бэлтгэх ажлын хүрээнд “Зочлох үйлчилгээний ажилтнуудад зориулсан мэргэжлийн сургалт” зохион байгуулагдсан. Сургалтад 3 ААН-ийн 4 иргэн оролцуулж, чадавхжуулж, гэрчилгээтэй болсон. 2025 оны байдлаар давхардсан тоогоор 48 ААН, иргэний | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөөлөлд хүнсний эрүүл ахуй, чанар аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулсан. | |
| 1.25. | “Жорлонгоо өөрчилье-хогоо шийдье” уриан дор сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах | ОНТ | Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо, хамрагдсан иргэдийн тоо | - | 4-с доошгүй ажлыг зохион байгуулж, 400-с доошгүй иргэдийг хамруулна. | Албан байгууллага, айл өрхийн дунд уриалгыг гаргасан. 2025 онд 30 өрх стандартын шаардлага хангасан 00-той болсон. | 90 |
| 1.26. | Татвар төлөгчдийн зан хандлага, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн татвар төлөгч бүрт хууль тогтоомжийн сургалт сурталчилгааг зохион байгуулах | ОНТ | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо | - | - | 2025 онд хөрөнгө болон малын тоо толгойн албан татвар, татвар төлөх хуулийн хугацаа зэрэг сэдвээр 1 удаа сургалтыг иргэдэд зохион байгуулж, 150 малчид, иргэдийг хамруулсан байна. ТАХ-дад татварын өр хураах ажиллагаа болон хувь хүний орлогын албан татварын тайлан гаргах зааврын талаар сургалтыг зохион байгуулж, 30 ТАХ хамрагдсан. | 85 |
| 1.27. | Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх | - | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 90 хувь | 100-с дээш хувь | Улсын төсөвт 184,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 161,3 сая төгрөг төвлөрүүлж 87,6%, аймгийн төсөвт 40,6 сая төгрөг төвлөрүүлэхээс 29,9 сая төгрөг төвлөрүүлж 73,7%, сумын төсөвт 696.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 568.2 сая төгрөг төвлөрүүлж 89,9%-ийн гүйцэтгэтэй, хүлээгдэж буй гүйцэтгэлээр татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 100%-д хүрэхээр байна. | 100 |
| 1.28. | Орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэлтийг дотоодын худалдан авалтаар дэмжих | УТ, ОНТ | Дотоодын худалдан авалтын дүн | 10 хувиар | Өмнөх оноос 15 хувиар нэмэгдүүлсэн байна. | Төсвийн байгууллагууд 2025 оны 12 дугаар сарын байдлаар орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдээс 381,1 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. | 100 |
| 1.29. | "Хоршоо хөгжүүлэх сан"-ийн эргэн төлөлтийг сайжруулж, шинээр зээл олгох нөхцөлийг бүрдүүлэх | - | Хугацаа хэтэрсэн зээлдэгчийн тоо | - | Хугацаа хэтэрсэн зээлийг бүрэн төвлөрүүлнэ. | 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 1 иргэний 4.4 сая төгрөгийн зээлийг бүрэн хаалгаж, 1 хоршоо 6 иргэний зээлийн эргэн төлөлтөд 39.7 сая төгрөгийн эргэн төлөлтийг хоршоо хөгжүүлэх санд төвлөрүүлсэн. Сумын Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Зээл олгох тухай” А/141 дүгээр захирамжаар "Стандарт хадгалалт, хөргүүртэй зоорь" болон "Бүтээгдэхүүн худалдаалах уут, сав баглаа, боодол, шошго үйлдвэрлэл" чиглэлээр Адуун толгой хошуу, Ламын бууцын хүрээ хоршоодод нийт 70 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийг олгосон байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.30. | Эвдэрч эзэнгүй орхигдсон газрын судалгааг гаргах | - | Судалгаанд хамруулсан газрын хэмжээ | - | Судалгаанд нийт нутаг дэвсгэрийг хамруулсан байна. | Уул уурхайн олборлолт болон авто замын бүтээн байгуулалтын улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон 2 газрын судалгааг гаргаж БОГ-т хүргүүлсэн. | 100 |
| 1.31. | Өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх | - | Өндөр ашиг шимтэй малын эзлэх хувь | Өндөр ашиг шимтэй малын эзлэх хувь 23,3% байна. | Өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувийг 24-д хүрнэ. | Сумын хэмжээнд өндөр ашиг шимтэй 41560 мянган толгой мал буюу сүрэгт эзлэх хув, 24,2%-тай байн. Өмнөх оноос 2.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| 1.32. | Бэлчээрийг нөхөн сэргээж, хамгаалах, хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулах | | Зохион байгуулсан талбайн хэмжээ, үр дүн | Нийт 7000 га талбайд зохион байгуулсан. | Бэлчээрийн судалгаанд үндэслэн 7000-с багагүй га-д зохион байгуулна. | Орон нутгийн хөгжлийн сангийн 6 сая төгрөгийн хөрөнгөөр Бэлчээрийн төлөв байдлын судалгаа хийлгэх ажлыг “Байгаль хамгаалах, судлах олон улсын судалгааны төв" НҮТББ-аар гүйцэтгүүлж байна. 2025 оны 12 дугаар сард судалгааны тайланг гэрээний дагуу хүлээн авна. | 85 |
| 1.33. | Бэлчээрийг усжуулах | - | Шинээр гаргасан усан хангамжийн тоо | Аймгийн БХС-ийн 27 сая төгрөгийн хөрөнгөөр Хараат багт 1 худаг гаргасан. | 1 худаг гаргана. | Хөдөөгийн 3 багийн 3 худгийг засварлах ажлыг ОНХС-ийн 8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж гүйцэтгэсэн. Дээрх ажлын хүрээнд Хараат багийн “Багийн төвийн худаг”, Лах багийн “Гурван цохионы худаг”, Доргонт багийн “Хэвтээгийн сайрмагийн худаг” гэсэн худгуудыг засварлах ажил хийгдсэн. 2025 онд улсын төвийн 29 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Лах багийн Жирмийн хөвөөнд инженерийн хийцтэй худаг шинээр гаргах ажлыг "Оптималтек" ХХК хийж гүйцэтгэн, 2025 оны 10 дугаар сард хүлээлгэн өгсөн. | 100 |
| 1.34. | Бэлчээрийн даац хэтэрсэн бүс нутаг дахь малын тоо, сүргийн бүтцийг оновчтой тодорхойлох | - | Эргэлтэд оруулсан малын тоо, бэлчээрийн даац, багтаамжийн хэтрэлт буурсан хувь | 5-10 хувь | 10-15 хувь | Сумын нийт газар нутгийн хэмжээ 231896 га, үүнээс бэлчээрийн талбай 206062 га, тус талбайд хонин толгойд шилжүүлснээр 147187 толгой мал бэлчээрлэх даацтай. 2024 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 324830 толгой мал бэлчээрлэж, бэлчээрийн даац 2.2 дахин хэтэрсэн байна. 2025 оны байдлаар зах зээлд амьдаар нь адуу 1388, үхэр 332, хонь 10644, ямаа 3989, нийт 16353 толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна. Мөн адууны мах 28959 кг, үхрийн мах 128040 кг, хонины мах 222200 кг, ямааны мах 130600 кг, тэмээний мах 200 кг, нийт 509999 кг буюу 509.9 тн махыг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.35. | Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, залуу малчдыг чадавхжуулах | | Сургалт, зөвлөгөөнд хамрагдсан малчид, тариаланч, албан хаагчдын тоо | Нийт малчдын 30 хувийг хамруулсан байна. | Нийт малчдын 50 хувийг хамруулсан байна. | “ШИНЭ ХОРШОО-ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” зөвлөгөөнийг зохион байгуулж, нийт 56 хоршооны 150 малчныг хамруулсан. Малын генетик нөөцийг судлан хөгжүүлэх, төлөвлөх, тайлагнах, ур чадвар олгох мэргэшүүлэх сургалтад Мал зүйчийг хамруулж, сургалтын төлбөрт 280 мянган төгрөгийг төлсөн. "Цагаан алт" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд дэвшилтэд техник, тоноглол, технологийг нэвтрүүлэх, түүхий эдийн бэлтгэлийн чанарыг сайжруулах зорилготой "Алтан хайч-2025" хонь ноослох Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 иргэнийг хамруулсан. | 100 |
| 1.36. | Малчдын бүлэг, хоршоонд тэжээлийн ургамал тариалах зориулалтаар газар эзэмшүүлж, үрээр хангах бодлого хэрэгжүүлэх | - | Тэжээлийн ургамал тариалсан малчдын бүлгийн тоо | - | 5-аас дээш малчдын бүлгийг дэмжиж, тэжээлийн ургамал тариална. | Булган аймгийн Могод сумын нутагт байршилтай "Өрхтий хишиг" ХХК-ийн 145 га талбайд 1 малчдын бүлэгийн 6 иргэн ногоон тэжээл тарьсан. Нийт 22000 боодол ногоон тэжээл хураан авсан. | 90 |
| 1.37. | Байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулах | - | Хамрагдсан өрхийн тоо | - | Өмнөх оноос 20 хувиар нэмэгдүүлнэ. | Малын индекжүүлсэн даатгалд нийт 38 иргэн даатгуулсан. Сумын нийт малчдын 10,4 хувь хамрагдсан. | 85 |
| 1.38. | Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө-Сэргэлт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | - | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | Хөтөлбөрийг 90-с дээш хувиар хэрэгжүүлнэ. | "Шинэ хөдөө-Сэргэлт" хөтөлбөрийн хүрээнд "ХӨДӨӨ АЖ АХУЙ-ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙ" ХХК-аас 11 иргэн 4*8 харьцаатай, 32м2 хэмжээтэй, 2,470,000 төгрөгийн үнэ бүхий хүлэмжийг 4 жил хувааж авах нөхцөлтэйгээр авсан. 2025 оны 10 дугаар сард Булган аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд нийлүүлэгдсэн 33,7 сая төгрөгний үнэ бүхий сүү, үйлдвэрлэлийн 6 төрлийн тоног төхөөрөмж, чацаргана үйлдвэрлэлийн 2 төрлийн тоног төхөөрөмжийг орон нутгийн өмчид бүртгэж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд гэрээ байгуулан ашиглуулахаар болоод байна. | 80 |
| 1.39. | Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах | - | Төлөвлөгөөний хэрэгжилт | 100 хувь хамруулсан байна. | 100 хувь хамруулсан байна. | 2025 оны төлөвлөгөөт арга хэмжээнд 10 дугаар сарын байдлаар бруцеллёз 30850, үхрийн дуут хавдар 2038, дотрын халдварт ходлого 22106, цусан халдварт 2216, галзуу 5015, бог малын мялзан 62433, хонины цэцэг 78476, листериоз 15951, шүлхий 10714, боом 27203, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт давхардсан тоогоор 234860 толгой малыг урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулсан байна. Мал дархлаажуулалтын ажилд МТТАТ-ын орлогоос 2.9 сая төгрөгийг зарцуулсан байна. | |
| 1.40. | Тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих “Атар-4” аяныг хэрэгжүүлэх | - | Төлөвлөгөөний хэрэгжилт | - | Төлөвлөгөөг 90-с дээш хувиар хэрэгжүүлнэ. | Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих "Атар-4" аяны хүрээнд тариалангийн талбайг эвдрэл, элэгдлээс хамгаалах зорилгоор ойн зурвас байгуулах, тариалангийн талбайд хөрсний шинжилгээ хийх зэрэг ажлууд хийгдсэн. 2025 онд "Өрхтий хишиг" ХХК нийт 1670 га эргэлтийн талбайтайгаас 858 га-д улаанбуудай, 780 га-д рапс, 10 га-д овьёос тариалсан. "Муку" ХХК энэ онд тариалалт хийгээгүй. | 80 |
| 1.41. | Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах | - | Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ | - | - | Өрхтий хишиг” ХХК тариалангийн талбайн хөрсийг хамгаалах ойн зурвасыг байгуулахаар хашааны энгийн бетон шон 800 ширхэг, булангийн гон 41 ширхэгийг гэрээгээр олгож ажилласан. | 85 |
| 1.42. | Хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх | - | Хураан авсан хүнсний ногоо | 10 хувь | Өмнөх оноос 15 хувиар нэмэгдүүлнэ. | Төмс 7.28 га талбайд тариалалт хийж өмнөх оноос 1.28 га талбайгаар, хүнсний ногоо 5.4 га талбайд тариалалт хийж өмнөх оноос 0.4 га талбайгаар тус тус өссөн байна. | 100 |
| 1.43. | Экологийн ач холбогдолтой газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах | - | Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээ | - | Шаардлагатай газар нутгийг хамгаалалтад авсан байна. | Улсын тусгай хамгаалалтад 20026.35 га, орон нутгийн тусгай хамгаалалтад 129220.79 га талбайг тус тус хамгаалалтад авсан. Нийт газар нутгийн 64.3 хувийг тусгай хамгаалалтад авсан байна. | 100 |
| 1.44. | Нэн ховор, ховор, зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах | - | Нэн ховор, ховор амьтдын тархац нутагт биотехникийн авах арга хэмжээний тоо | Ажил хийгдээгүй. | 2 удаагийн арга хэмжээг авна. | Хийгдээгүй. | 0 |
| 1.45. | Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоож, тэмдэгжүүлэлт хийх | - | Хамгаалалтын бүс тогтоосон газрын тоо, байршуулсан тэмдэгжүүлэлтийн тоо, | - | Сумын төв дэх 2 худгийн хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлсэн байна. | Хийгдээгүй. | 0 |
| 1.46. | Хүн амын баталгаат усан хангамжийг сайжруулна. | 80 сая | Стандартын шаардлага | 1 худагт цэвэршүүлэх | 1 худгийг гаргаж, тоног | Сумын ОНХС-ийн 138 сая төгрөгийн хөрөнгөөр "Хүн амын ундны усан хангамжийг сайжруулах" ажил хийгдэж байна. Уг ажлын хүрээнд сумын төвд шинээр 2 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хангасан ундны усны худгийн тоо | төхөөрөмжийг суурилуулсан. | төхөөрөмжийг суурилуулна. | худаг гаргах, 2 худагт ус цэвэршүүлэгч төхөөрөмж, ухаалаг худгийн төхөөрөмж тавих ажил хийгдэж байна. Ажлын явц 90%-тай байна. Мөн Наран хороонд байрлалтай ундны усны худгийн шүүлтүүрийг солих ажлыг 4.2 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн. Мөн худгийн 1.5 кв-н гүний насосыг солих ажлыг ОНХС-ийн 750 мянган төгрөгийн хөрөнгөөр хийлээ. | |
| 1.47. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд жилд 1.5 саяас доошгүй ширхэг мод, бут, сөөг тарьж ургуулна. | - | Тарьсан мод бутны тоо | - | 5000 ш мод бут тарина. | “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хаврын тариалалтаар 1235ш мод, тарвсан. “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулж, ЗДТГ 210ш мод, “Нарлаг” цэцэрлэг 50ш мод, ЕБС 50ш мод, Соёлын төв 50ш мод, ЭМТ 21ш мод, Ахмадын холбоо 9ш мод, ААНэгж, иргэд 410ш мод, “Хөвөнтөн ой” ХХК намрын нөхөн тариалалтаар 1000ш мод, нийт 5 төрлийн 1800 ширхэг мод тарьсан байна. | 100 |
| 1.48. | Элсний нүүдлийг тогтоон барих ажлын хүрээнд хамгаалалтын зурвас байгуулж буй хөвөнтөн ой ХХК-д хяналт тавих | - | Ойжуулалтын талбайн ургалтын хувь | - | Өмнөх жилүүд болон тухайн жилийн ургац 80-с дээш хувьтай ургасан байна. | "Хөвөнтөн ой" ХХК засмал зам дагуух ойн зурвас байгуулах ажлын хүрээнд 3 га талбайг хашиж хамгаалсан. Энэ онд 5 төрлийн 1520 мод нөхөн тариалалт хийсэн. | 100 |
| 1.49. | “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг хэрэгжүүлнэ. | - | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80 хувьтай | Төлөвлөгөөг 90-с дээш хувиар хэрэгжүүлж ажиллана. | “Цэвэр орчин цэмцгэр Дашинчилэн” аяны хүрээнд тусгай удирдамжийн дагуу бүх нийтийн хог цэвэрлэгээг 3 удаа, улсын чанартай авто замын хогийг 2 удаа, “Чингийн уулзвар”, “Гэр гуанзны уулзвар”-ыг 1 удаа цэвэрлэх ажлыг зохион байгуулсан. ОНХС-аар 60 сая төгрөгийн хөрөнгөөр “Хогийн цэгийг дарж, булшлах” ажил, 120 сая төгрөгий хөрөнгөөр “Хог хаягдлын менежментийг сайжруулах” ажил, хогийн цэгийг хашаажуулах, дахивар авах цэгийг байгуулах, хог хаягдал преслэгч байршуулах хэсгийг шинээр байгуулах, хогийн цэгт зогоон татах зэрэг ажлыг хийж байна. | 100 |
| 1.50. | Айл өрх аж ахуйн нэгжүүдийн хөрс бохирдуулагч нүхэн жорлонг буулгах, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох | - | Стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжийн тоо | - | 10-аас доошгүй айл өрхийг стандартад нийцсэн 00-той болгоно. | 2025 оны жилийн эцсийн байдлаар 30 айл өрх стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.51. | Төрийн албан хаагчийн орон сууц хөтөлбөрийн зураг төсвийг хийлгэх, газрын асуудлыг шийдвэрлэх | ОНТ | Гүйцэтгэлээр | - | Зураг төсөв батлагдаж, газар гэрчилгээжсэн байна. | ОНХС-ийн хөрөнгөөр төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны зураг төсвийг "ММ архитектур" ХХК-иар хийлгэж байна. Орон сууцны газрыг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан. | 85 |
| 1.52. | Төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодтой хамтран үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарт ажиллагсадыг чадавхижуулах сургалт арга зүйгээр тасралтгүй хангаж, гадаад дотоодын арга хэмжээнд оролцоход дэмжлэг үзүүлэх | ОНТ | Чадавхижсан бизнес эрхлэгчийн тоо | - | 20-с дээш бизнес эрхлэгчдийг хамруулсан байна. | 2025 оны 05 сарын 22-ны өдөр “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран “Бизнес төсөл хэрхэн боловсруулах” сургалтыг зохион байгуулж, нийт 18 хоршооны төлөөллийг чадавхжуулсан. 2025.03.29-ны өдөр аймгийн СХЗХ-ээс “Стандарттай Булган” аяны зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөг төрийн албан хаагчид болон үйлдвэрлэл, худалдаан үйлчилгээний салбарт ажиллагсдад танилцуулах сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 1.53. | Хоол, хүнсний бүтээгдэхүүний эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хяналтыг хэрэгжүүлэх | ОНТ | Хэрэгжилтийн хувь | - | Төлөвлөгөөг 90-с дээш хувиар биелүүлнэ. | 2025 онд "Хүнсний орон тооны бус зөвлөл" 4 удаа, аймгийн ХХААГ-ын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, ЭМГ-ийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нар 2 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, 1 ААН-д торгуулийн арга хэмжээ авч, 6 ААН-д хугацаатай албан шаардлага, 8 ААН-д албан мэдэгдэл өгч, зөрчлийг арилган ажилласан. | 100 |
| 1.54. | “Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | ОНТ | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг 90-с дээш хувиар хэрэгжүүлнэ. | “Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 06 сард хоршоог хөгжүүлэх сангаас "Адуун толгой хошуу" хоршоонд "Стандарт хадгалалт, хөргүүртэй зоорь" чиглэлээр 50 сая төгрөгний хөнгөлттэй зээлийг олгосон. Зээлийн зориулалтын дагуу 40м2 хэмжээтэй махны хөргүүр бүхий мах хөлдөөх хэсэг, 20м2 хэмжээтэй хүнсний ногооны зоорьтой болсон. 2025 оны 10 дугаар сард Булган аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд нийлүүлэгдсэн 8.6 сая төгрөгний үнэ бүхий сүү, үйлдвэрлэлийн 6 төрлийн тоног төхөөрөмж, чацаргана үйлдвэрлэлийн 3 төрлийн тоног төхөөрөмжийг орон нутгийн өмчид бүртгэж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд гэрээ байгуулан ашиглуулахаар болоод байна. | 85 |
| 1.55. | “Амар тайван Булган” хөтөлбөр хэрэгжүүлэх | ОНХС | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн | “Амар тайван Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулан, төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөө 3 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг төлөвлөн, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөг 90-с дээш хувиар хэрэгжүүлнэ. | хэрэгжилтийг 2 удаа тооцон ажилласан. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар сургалт, нөлөөллийн ажлыг 37 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 2669 иргэнийг хамруул, нийт 7,096,600 төгрөгийг зарцуулсан байна. | |
| 1.56. | “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | УТ, ОНТ | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 85 хувь | Төлөвлөгөөг 90-с дээш хувиар биелүүлнэ. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргасан. Хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар гаргахаар хүлээгдэж байна. ЗДТГ-ын 2025 оны үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор иргэдээс санал асуулгыг цахим хэлбэрээр авсан. Санал асуулгад нийт 120 иргэн хамрагдсан. | 100 |
| 1.57. | Монгол Улсын Шадар сайд-Булган аймгийн Засаг даргатай 2024 онд байгуулсан гэрээний дагуу 2025 онд гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах. | ОНТ | Сургуулилтын дүн | - | Сургуулилтад 90-с дээш үнэлгээ авна. | Булган аймгийн хэмжээнд 2025.09.24-09.26 өдрүүдэд зохион байгуулагдсан гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтын бэлтгэлийг ханган амжилттай оролцсон. Сумын шуурхай штабын удирдлага, Төлөвлөлтийн баг, Ажиллагааны баг, Санхүү, хангалтын баг, Захиргааны багийн гишүүд цагийн байдлын дагуу урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг төлөвлөн ажилласан. | 100 |
| 1.58. | Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох чадавхыг бэхжүүлж, иргэдийн боловсролыг дээшлүүлэх | ОНТ | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | - | Сургалтад 200-с дээш иргэдийг хамруулна | Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авах ажлын хүрээнд газар хөдлөлтийн бэлэн байдал, осол гэмтэл, галын аюулгүй байдлаас сэргийлэх нь, аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг шалгалт, сургалтыг 3 удаа зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 460 иргэнийг хамруулан ажилласан байна. Онцгой комиссын шуурхай штабыг шинэчлэн байгуулж, шуурхай штабын бие бүрэлдэхүүнд Улсын Онцгой комиссын даргын 2025.04.23-ны өдрийн 05 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой комиссын шуурхай штабын ажиллах журам”-ын сургалтыг зохион байгуулсан. Аймгийн ОБГ-аас Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг шалгалт, сургалтыг тус суманд 5-р сард зохион байгуулж, Онцгой комисс, Шуурхай штаб, Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг сургалтад хамруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.59. | Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулж сургалт, дадлага зохион байгуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг ажиллах нөхцлөөр хангаж техник, зэвсэглэмжийг нэмэгдүүлэх | ОНТ | | - | | Орон нутгийн хөгжлийн сангийн 6.5 сая төгрөгийн хөрөнгөөр Эрэн хайх аврах бүлэгт маяак, старлинк, цахилгаан үүсгүүр зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч, хүлээлгэн өгсөн. | 100 |
| **Аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт ” үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын дундаж** | | | | | | | **88,4** |
| **Хоёр. Аймаг, сумын Засаг даргын хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 2.1. | "Цахим Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлэх | ОНТ | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг 90-с дээш хувиар хэрэгжүүлнэ. | ОНХС-ийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд сумын төвийг камержуулахад 16,6 сая төгрөг, шинээр баригдсан дотуур байрыг камержуулахад 13,6 сая төгрөгийг зарцуулсан. Dashinchilen.bu.gov.mn сайтыг шинэчлэж, Dashinchilen.bu.gov.mn сайтаар иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах боломжийг бүрдүүлсэн. Мөн иргэд, олон нийтийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг цаг алдалгүй 7034-6634 дугаарын нээлттэй утсаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн. | 70 |
| 2.2. | Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн ашиглалтыг нэмэгдүүлж, цаасан суурьтай хэрэглээг бууруулах ажлыг зохион байгуулах | ОНТ | Гүйцэтгэлээр | - | Бүх албан бичиг цахимжсан байна. | Дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд бүх төрийн албан хаагчдыг холбосон. Төрийн албан хаагчид системийг бүрэн хэрэглэж сурсан. | 90 |
| 2.3. | Төрийн цахим үйлчилгээний “Смарт” төв, 24/7 цагаар ажиллах ухаалаг цэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах | ОНТ | Үйлчилгээ авсан иргэдийн тоо | - | 1000-с дээш иргэд үйлчилгээ авсан байна. | ЗДТГ-т 24/7 цэгийг байгуулж, хаягжилтын зардалд 173500 төгрөгийг зарцуулсан. Мөн Киоск төхөөрөмж, болон E-mongolia лавлагаа тодорхойлолтыг жилийн эцсийн байдлаар сумын иргэдийн 75 хувь нь авч үйлчлүүлсэн байна. | 95 |
| 2.4. | "Нээлттэй хаалганы өдөр"-ийг зохион байгуулах | ОНТ | Зохион байгуулсан тоо, хамрагдсан иргэд | - | 1 удаа зохион байгуулж, 200-с дээш иргэдийг хамруулна. | ЗДТГ-ын газрын байгууллага сурталчлах өдөрлөгийг 1 удаа зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр байгууллагын үйл ажиллагаа, төрийн албан хаагчдын ажлын чиг үүргийг танилцуулах, ЗДТГ-ын 2025 оны 1 дүгээр улирлын ажлын тайлан, сумын 2025 оны батлагдсан төсвийг иргэдэд танилцуулах, иргэдээс ЗДТГ-ын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааг авах ажлыг зохион байгуулж, ЗДТГ-ын ахмад, дунд, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | залуу үеийн хамтарсан “Өлзийжаргалангийн орон" уран бүтээлийн тоглолтыг хийсэн. Байгууллага сурталчлах өдөрлөгт 214 иргэн хамрагдсан. 2025 оны 06 дугаар сард хөдөөгийн 3 багт “Нүүдлийн Тамгын газар"-ыг ажиллуулж, төрийн үйлчилгээг ойроос хүргэх ажлыг зохион байгуулсан. Нүүдлийн тамгын газраас 89 иргэн үйлчилгээ авсан. Аймгийн УБХ-тэй хамтран “Зөвлөе-Бүртгэе “нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, нийт 50 иргэн хамрагдсан. 2025 оны байдлаар "Дашинчилэнгийн мэдээ" мэдээллийн хуудсыг 3 дугаар хэвлүүлж, давхардсан тоогоор 545 өрхөд хүргэсэн. | |
| 2.5. | Төрийн байгууллагуудын барилгын засварын ажлыг үе шаттай зохион байгуулах | ОНТ | Гүйцэтгэлээр | 2 коридор зассан | Иргэнийтанхим, 1 цэг засварлана | Төрийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах ажлын хүрээнд ЗДТГ-ын "Иргэний танхим", "Нэг цэгийн өрөө"-г засварлах, тохижуулах ажлыг байгууллагын төсвийн 39 сая төгрөгийг хөрөнгөөр хийсэн. Сумын 2025 оны ОНХС-ийн 15 сая төгрөгийн хөрөнгөөр Лах багийн төвийн гадна орчныг тохижуулах, хуучин барилгын доторлогоо болон гадна фасадыг шинэчлэх, 2 барилгыг тохижуулах зэрэг ажил хийгдсэн. | 100 |
| 2.6. | Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх | УТ, ОНТ | Хамтран ажилласан ажил, арга хэмжээ тоо | ЭХ, ЗХ-той хамтран 2 арга хэмжээг зохион байгуулсан | Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран 5 ажил, арга хэмжээг зохион байгуулна | “Хар Бух” шагайн холбоотой хамтран ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдад “Үндэсний уламжлал шагайн харваа, соёлын биет бус өв” сэдвээр сургалтыг зохион байгуулсан. Ахмадын холбоо болон эмэгтэйчүүдийн холбоотой хамтран Алдарт эхийн I, II дугаар одон, Дархан бэр, Уран бэрийн шагнал гардуулах, Олон улсын Ахмадын баярын арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулан хамтран ажилласан. Арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 550 иргэн хамрагдсан. Улаанбаатар хот дах нутгийн зөвлөлтэй хамтран 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд Улаанбаатар хот дах нутгийн зөвлөлийн шинэ жил, Япон улсын Чиба мужын Широко хоттой хамтын ажиллагаагаа эхлүүлэх ажлууд хийгдсэн. Мөн Улаанбаатар хот дах нутгийн зөвлөлийн тэргүүлэгч сумын уугуул Б.Баярмагнай, Б.Баатарсайхан нар санаачлан Дашинчилэн сумын Тэргүүн шагнал болох “ӨЛЗИЙ ЖАРГАЛАНГИЙН ОРОН-НУТГИЙН БАХАРХАЛ” бүтээлийг ах дүүсийн хамтаар бүтээн Улаанбаатар хот дах нутгийн зөвлөлд хүлээлгэн өгсөн. Улаанбаатар хот дах нутгийн зөвлөлөөс жил бүр сум орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөж, нутаг орондоо хувь нэмрээ оруулсан | 85 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрхмүүдийг алдаршуулж энэхүү шагналыг олгож байх юм. | |
| 2.7. | Төрийн байгууллагуудын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх | УТ, ОНТ | Хангалтын хувиар | 2 ТАХ-н тоног төхөөрөмжийг шинэчилсэн | ТАХ-н техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг 40 хувьд хүргэнэ | Техник тоног төхөөрөмжийг сайжруулах ажлын хүрээнд ЗДТГ-ын газрын албан хаагчдын компьютер, техник хэрэгслийг шинэчлэхэд 32,4 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: ЗДО, ХЭЗАХМ-ний компьютерийг шинэчлэх, АБХЭ-д хурдан сканнер, цагдаагийн хэсэгт суурин компьютер, 3 үйлдэлт принтер, хэвлэл мэдээллийн ажилтанд дрон, видео бичлэгийн төхөөрөмж, зургийн аппарат, мал эмнэлгийн улсын байцаагчид суурин компьютер зэргийг худалдан авч, хүлээлгэн өгсөн байна. | 100 |
| 2.8. | Аймгийн удирдах ажилтны улирлын зөвлөгөөнд оролцож, цаг үеийн болон салбарын мэдээ, мэдээллийг авч, сум, орон нутгийн бодлого, төлөвлөлтийг хангах ажлыг зохион байгуулах | - | Зөвлөгөөнд оролцсон эсэх | - | 4 удаа оролцсон байна | Аймгийн удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд нийт 3 удаа хамрагдсан. Мөн Хойд бүсийн Бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөнд удирдах ажилтан болон албан хаагчдын бүрэн хамруулсан. | 100 |
| 2.9. | Аймгийн “Төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллах | УТ, ОНТ | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 85 хувь | 90 хувь | Төрийн албан хүний нөөцийг хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар төрийн албан хаагчдын дунд сургалтыг 11 удаа 28 сэдвийн хүрээнд зохион байгуулж, давхардсан тоогоор 395 албан хаагч хамрагдсан байна. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд ТАХ-дын техник тоног төхөөрөмж шинэчлэхэд 32,4 сая төгрөг, ТАХ-дад ажлын хувцас хийлгэхэд 6,3 сая төгрөг, ТАХ-ийн ажиллах орчин нөхцлийг сайжруулахад 39,9 сая төгрөг зарцуулсан. 2025 онд 6 төрийн албан хаагчид зэрэг дэвийг уламжлан олгуулсан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хагас жилийн байдлаар 6 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 95 албан хаагчийг хамруулсан байна. “Чадварлаг төрийн албан хаагч, хариуцлагатай төрийн алба” сарын аяны хүрээнд ИТХ, ЗДТГ-ын ахмад, дунд, залуу үеийн уулзалт, хэлэлцүүлэг, спортын уралдаан тэмцээн, хуулийн мэдлэгийг нэмэгдүүлэх АХА тэмцээн, Монгол | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичиг болон хууль эрх зүйн сургалт, нөлөөллийн ажил, төрийн захиргааны албан хаагчдын өдрийн баярын хурал зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан. | |
| 2.10. | Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог чадавхжуулах сургалтад хамруулж, ёс зүйн зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлэх | УТ, ОНТ | Хамрагдсан Чадавхжуулах сургалтын тоо, төлөвлөгөөний хэрэгжилт | Ёс зүйн сургалтыг 1 удаа хийж, 5 албан хаагчийг хамруулсан байна. | Ёс зүйн хорооны гишүүдийг 1 удаа сургалтад хамруулж, төлөвлөгөөг 90-с дээш хувиар биелүүлнэ. | Байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан, 13 ажил үйлчилгээг төлөвлөн, батлуулж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Төрийн албан хаагчдын дунд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Байгууллагын стандарт” сэдвийн хүрээнд сургалтыг нийт 6 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 95 албан хаагч хамрагдсан байна. "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” хойд бүсийн зөвлөгөөнд байгууллагын ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга нар 2 өдрийн танхимын сургалт зөвлөгөөнд хамрагдсан. Ёс зүйн дэд хорооноос албан хаагчдаас ёс зүйн сэтгэл ханамжийн судалгааг 1 удаа, иргэдээс 1 удаа авч, сэтгэл ханамжийн судалгааны дүнг нэгтгэх ажил хийгдэж байна. 2025 онд ёс зүйн зөрчил гараагүй болно. | 100 |
| 2.11. | Орон нутагт ажиллаж байгаа шинэ, залуу төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтад хамруулах, түрээсийн орон сууцаар үе шаттайгаар хангах ажлыг зохион байгуулах | УТ, ОНТ | Түрээсийн орон сууцанд хамрагдсан албан хаагчийн тоо | 4 | 1 | ЗДТГ-ын эзэмшлийн 5 орон сууцанд ЗДТГ-ын 1 төрийн албан хаагч, эрэн хайх аврах бүлгийн 3 төрийн албан хаагч, Соёлын төвийн 1 албан хаагч амьдарч байна. | 95 |
| 2.12 | | УТ, ОНТ | Чадавхжуулах сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 1 | 3 | 2025 оны жилийн эцсийн байдлаар төрийн албан хаагчдын дунд сургалтыг 11 удаа 28 сэдвийн хүрээнд зохион байгуулж, давхардсан тоогоор 395 албан хаагч хамрагдсан | 95 |
| 2.13. | Төрийн албыг салбар бүрээр дотоод болон гадаадад туршлага судлуулан, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх нөхцөл бололцоог бий болгох | УТ, ОНТ | Гадаадад туршлага солилцсон албан хаагчдын тоо | - | 2 | Гадагшаа туршлага судалсан албан хаагч байхгүй. | 0 |
| 2.14 | | УТ, ОНТ | Дотоодод туршлага солилцсон албан хаагчдын тоо | - | 5 | “Хоршоологчид тогтвортой хөгжилд-2025” хоршлоологчдын улсын зөвлөгөөн 2025 оны 10 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт зохион байгуулагдаж, тус зөвлөгөөнд 1 төрийн албан хаагч хамрагдсан. Аймгийн хэлтэсээс статистикийн мэдээ, мэдээллийг зөв цуглуулах, статистикийн мэдээллийг | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгтгэн боловсруулах, мэдээллийг олон нийтэд хүргэх, статистикийн мэдээллийн чанарыг дээшлүүлэх, ойлголт өгөх урд бүсийн сургалтыг Дашинчилэн суманд зохион байгуулсан. Тус сургалтад ТТСМ, БЗД нар хамрагдсан. | |
| 2.15. | Удирдлагын академийн төрийн албанд шинээр томилогдсон болон төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдан сурч төгсөөгүй албан хаагчдыг төгсгөх нөхцөл боломжоор хангаж ажиллах | УТ, ОНТ | Удирдлагын академийг төгссөн байна | - | Удирдлагын академид сураад төгсөөгүй байгаа албан хаагчдыг төгсгөх нөхцөл боломжоор хангаж ажиллах | Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 төрийн албан хаагч хамрагдаж байна. | 80 |
| 2.16. | Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлт дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системийг бүрэн нэвтрүүлэх. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтөд байгууллагын удирдлагын тоон гарын үсгийг ашиглаж хэвших | УТ, ОНТ | ERP системд холбогдсон төрийн албан хаагчийн тоо | 20 | Албан хаагчдын 100-аас доошгүй хувь ERP системд холбогдож, албан хэрэгцээндээ хэрэглэж хэвшүүлнэ | Засаг даргын Тамгын газрын нийт төрийн албан хаагчдыг ERP системд холбож, албан хэрэгцээнд хэрэглэж хэвшүүлсэн байна. Мөн төрийн албан хаагчдын ирц бүртгэлийг ERP системээр хийж хэвшсэн. | 100 |
| 2.17. | | УТ, ОНТ | Тоон гарын үсгийн ашиглалтын хувь | 400 иргэнд | Тоон гарын үсгийн хэрэглээ 100%-д хүрсэн байна. | Тоон гарын үсгийн хугацаа дууссан, хугацаагаа сунгуулахаар хүсэлтийг илгээсэн. | 80 |
| 2.18. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нийтийн мэдээлэл хариуцагч байгууллагуудын мэдээллийг **shilen.gov.mn** цахим хуудсаар байнга ил тод нээлттэй байлгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах | ОНТ | Үнэлгээний хувь | - | 90 хувиас доошгүй үнэлүүлсэн байна. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын хангах хуулийн хүрээнд нийтэд нээлттэй мэдээллэх мэдээллийг байгууллагын Dashinchilen.bu.gov.mn цахим сайтад тухай бүр нь байршуулан ажиллаж байна. | 100 |
| 2.19. | Засгийн газрын 2024 оны 12 сарын 04-ний өдрийн 208 | ОНТ | Хэрэгжилтийн хувь | - | Мэдээллийн 90-с доошгүй хувь нь www.gov.mn | Dashinchilen.bu.gov.mn вэб сайтыг шинэчлэсэн. Вэб хуудсанд мэдээлэл оруулах цахим сургалтад 5 албан | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах | | | | сайтад шилжсэн байна. | хаагч хамрагдаж мэдээллүүдээ шинэчлэн оруулж байна. | |
| 2.20. | Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, саналыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, хэрэгжилтийг улирал тутам тайлагнах, байгууллагын цахим хуудаст байршуулах | УТ, ОНТ | Шийдвэрлэлтийн хувь | 2 удаа тайлагнсан. | 100% шийдвэрлэсэн байна. | Иргэдээс ирсэн өргөдөл гомдол саналыг хүлээн авах 70346634 дугаартай нээлттэй утсыг ажиллуулж байна. 2025 онд нийт 90 өргөдөл гомдлыг хүлээн авч, бүртгэл хяналтад оруулж, хэрэгжилтийг улирал бүр тооцон аймгийн ТЗУХ-т 4 удаа хүргүүлэн ажилласан. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 85%-тай байна. | 100 |
| 2.21. | “Сайхан Монгол” телевиз, “Булганы мэдээ” сонинтой хамтран ажиллах | УТ, ОНТ | Сонин болон сошиалаар хүргэсэн мэдээ мэдээллийн тоо | - | 7-с доошгүй мэдээ мэдээллийг хүргэсэн байна. | “Сайхан Монгол” телевизээр “Одонтой ээжүүд”, “Жишиг эрүүл мэндийн төв”-н барилгын нээлтийг дамжуулах ажил, “Булганы мэдээ” сонинд 150 хүүхдийн дотуур байр, Жишиг эрүүл мэндийн төвийн барилга, ариутгал татуургын ажил зэрэг 7 мэдээ мэдээллийг хэвлүүлж, хамтран ажилласан. | 85 |
| 2.22. | Аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнах | УТ, ОНТ | Хугацаанд нь тайлагнасан байдал | 2 удаа тайлагнасан. | 11 сарын 01-ний өдрийн дотор тайлагнаж, хэрэгжилтийг 100 хувь биелүүлнэ. | Аймгийн Засаг даргын “Булганы Сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцон, хугацаанд мэдээлж ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 144 зорилтын хүрээнд 214 арга хэмжээний хэрэгжилт 92.4 хувьтай гарсан. | 90 |
| 2.23. | Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран Хоршооны дүрмийн 9.1 дэх хэсэг шинэчлэн бүртгэх ажлыг эрчимжүүлэх | - | Бүртгэгдсэн хоршооны дүрмийн тоо | - | 3-аас доошгүй | Монгол улсын Засгийн газраас улс орон даяар өрнүүлсэн “Шинэ хоршоо” хөдөлгөөн тус суманд идэвхитэй өрнөж, тайлант хугацаанд 5 хоршоо шинээр бүртгэгдэж, үйл ажиллагаа явуулж эхлэсэн. | 100 |
